



БҮРТГЭЛИЙН ХУУДАС

Албан хэрэгцээнд

Бүртгэлийн дугаар

Бүртгэсэн сар, өдөр, он

Бүртгэсэн ажилтан

Хамтрагчаар элсэгчийн мэдээлэл

Овог	Нэр	Эр Хүйс (✓)	Эм
------	-----	----------------	----

Гэрийн хаяг	Төрсөн сар, өдөр, он
-------------	----------------------

Регистр	Утасны дугаар	E-Mail хаяг
---------	---------------	-------------

Спонсорын мэдээлэл

Спонсорын дугаар	Спонсорын нэр
------------------	---------------

 * хэрвээ спонсорын мэдээлэл нь элсүүлэгчийн мэдээлэлтэй ижил бол тэмдэглэнэ үү. (✓)

Элсүүлэгчийн мэдээлэл

Элсүүлэгчийн дугаар	Элсүүлэгчийн нэр
---------------------	------------------

ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

Нэг талаас 110751001 тоот дугаартай Unicity International Inc.-ийн хамтрагч А.Хашчулуу (цаашид “ЗУУЧЛАГЧ” гэх), нөгөө талаас энэхүү гэрээний салшгүй хавсралт болох бүртгэлийн хуудсанд заагдсан хуулийн этгээд эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч (цаашид “ХАМТРАГЧ” эсвэл “БОРЛУУЛАГЧ” гэх) нар энэхүү гэрээг (цаашид “ГЭРЭЭ” гэх) байгуулав.

НЭГ. ГЭРЭЭНИЙ АГУУЛГА

- 1.1. Энэхүү гэрээний дагуу ЗУУЧЛАГЧ нь ХАМТРАГЧ-д захиалсан бүтээгдэхүүнийг (цаашид “бараа” гэх) нийлүүлэх, ХАМТРАГЧ нь энэхүү гэрээнд заасан журмын дагуу бараа захиалан авах ба ЗУУЧЛАГЧ нь ХАМТРАГЧ-аар ажиллах этгээдэд Unicity International Inc.-ийн ХАМТРАГЧ болох, бүртгүүлэх, цаашид үйл ажиллагаагаа хэвийн явуулахад дэмжлэг туслалцаа үзүүлэх үндсэн үүрэгтэй.
- 1.2. ХАМТРАГЧ-ийн нэрийн өмнөөс Юниситигийн Дүрэм, Журам, Борлуулагчийн гэрээний нөхцлүүд, Цалинжуулалтын систем болон бусад холбогдох дүрэм, журам, гэрээний нөхцөл, зүйл заалтуудаар Unicity International Inc.-тай харилцах, хэлэлцээр хийхийг ЗУУЧЛАГЧ-д зөвшөөрч байна.

ХОЁР. БАРАА НИЙЛҮҮЛЭХ ЖУРАМ, ТАЛУУДЫН ҮҮРЭГ

- 2.1. ХАМТРАГЧ захиалгын маягтаар бараа захиалан авна. ХАМТРАГЧ барааны төлбөрийг энэхүү гэрээний 3-р зүйлд заасан журмаар төлнө.
- 2.2. ХАМТРАГЧ нь барааг захиалахдаа барааны үнийг бүрэн төлж барагдуулсан байх үүрэгтэй. Unicity International Inc.-ийн Борлуулагчийн гэрээний нөхцлүүд болон Unicity International Inc.-ийн дүрэм, журам, бодлого нөхцлүүдийг энэхүү гэрээг байгуулахад ХАМТРАГЧ-д танилцуулах ба гэрээ байгуулагдсанаар уг дүрэм, журмыг бүрэн хүлээн зөвшөөрсөнд тооцно.
- 2.3. ХАМТРАГЧ нь барааг хүлээн авах үед чанарын дутагдалтай барааг ЗУУЧЛАГЧ-д буцаан өгч, зохих чанарын бараагаар солиулан авах эрхтэй. Барааг хүлээн авсанаас хойш 3 хоног өнгөрсөн тохиолдолд ЗУУЧЛАГЧ нь чанарын доголлын тухай гомдлын шаардлагыг ХАМТРАГЧ-ээс хүлээн авахгүй.
- 2.4. ХАМТРАГЧ нь барааг ЗУУЧЛАГЧ-аас тогтоосон үнээс багагүй үнээр борлуулах үүрэгтэй.
- 2.5. Бараа захиалсанаас хойшхи бүх үйлдлийг ХАМТРАГЧ нь өөрийн биеэр хариуцах бөгөөд Монгол улсын хуулийн дагуу ногдох татвар, хураамжийг ХАМТРАГЧ өөрөө хариуцан барагдуулах үүрэгтэй.

ГУРАВ. БАРААНЫ ҮНЭ БА ТООЦОО ХИЙХ ЖУРАМ

- 3.1. Тогтоогдсон барааны үнийг тухайн хугацааны үнийн жагсаалтад тусгасан байна. Барааны үнэ нь т.н-ээр томъёологдоно.
- 3.2. Барааны үнийг тухайн өдрийн ам.доллар худалдаж авах ханшаар тооцож төгрөгөөр төлөх ба бэлэн болон бэлэн бусаар хийж болно.
- 3.3. ЗУУЧЛАГЧ бараанд хөнгөлөлт үзүүлэх эрхтэй.
- 3.4. ЗУУЧЛАГЧ ХАМТРАГЧ-д өөрийн үйлчилгээний төлбөр ногдуулах эрхтэй.

ДӨРӨВ. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

- 4.1. ХАМТРАГЧ нь барааг жижиглэн худалдаалах аливаа цэгээр худалдаалахыг хориглоно.
- 4.2. ХАМТРАГЧ нь энэхүү гэрээний 2.2-ыг хэлбэрэлтгүй дагаж мөрдөх үүрэгтэй бөгөөд аль нэг заалтыг зөрчсөн тохиолдолд энэхүү гэрээгээр олгогдсон ХАМТРАГЧ-ийн эрхээ бүрмөсөн алдаж, ЗУУЧЛАГЧ ямар нэг болзолгүйгээр гэрээг дангаар цуцлах эрхтэй.
- 4.3. Энэхүү гэрээний 4.1-4.2-р зүйлүүдэд заасан тохиолдол гаргасан талаар ЗУУЧЛАГЧ-ийн шийдвэрт ХАМТРАГЧ гомдол гаргахгүй.
- 4.4. ХАМТРАГЧ гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зөрчсөний улмаас ЗУУЧЛАГЧ-д эсвэл гуравдагч этгээдэд учруулсан хохирлыг бүрэн хэмжээгээр нөхөн төлөх үүрэгтэй.
- 4.5. ХАМТРАГЧ бараа захиалан авсанаас хойш 1 жилийн хугацаанд дахин бараа захиалан аваагүй тохиолдолд энэхүү гэрээ дуусгавар болсонд тооцогдоно.
- 4.6. ХАМТРАГЧ нь бүртгэлийн хуудсанд дахь өгөгдөлүүдийг үнэн зөв бөглөх үүрэгтэй. Үнэн зөв бөглөөгүйгээс үүдэн гарах хохирлыг нөхөн төлнө.
- 4.7. ХАМТРАГЧ нь энэхүү гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг, ашиг сонирхлоо ЗУУЧЛАГЧ-ийн бингээр өгсөн зөвшөөрөлгүйгээр бусад шилжүүлж болохгүй, ЗУУЧЛАГЧ-ийн оролцоогүйгээр бараа захиалан, хүлээн авсан тохиолдолд энэхүү гэрээг ЗУУЧЛАГЧ дангаар цуцлах эрхтэй ба үүнээс үүдэн гарах хохирлыг ХАМТРАГЧ хариуцан барагдуулна.

ТАВ. БУСАД

- 5.1. Unicity International Inc.-ийн Борлуулагчийн гэрээний нөхцлүүд болон Unicity International Inc.-ийн дүрэм, журам, бодлого нөхцлүүд нь энэхүү гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг мөн бөгөөд бүх заалтууд нь энэхүү гэрээний заалтуудын нэгэн адил үйлчилэх ба орчуулгын утгын алдааг ЗУУЧЛАГЧ хариуцахгүй.
- 5.2. Энэхүү гэрээний хавсралт бөгөөд гэрээний бүрэлдэхүүн хэсэг болох бүртгэлийн хуудсанд тусгагдсан ХАМТРАГЧ-ийн бүртгэлийн дугаарыг ХАМТРАГЧ-д олгож, энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурсанаар хүчин төгөлдөр болсонд тооцогдох ба хууль, тогтоомж, гэрээнд зааснаар цуцлах хүртэл хугацаагүй үйлчилнэ.
- 5.3. Энэхүү гэрээтэй холбогдон үүсч болох аливаа маргаан, санал зөрөлдөөнийг талууд хэлэлцээний журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх ба боломжгүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 5.4. Энэхүү гэрээнд шууд заагаагүй аливаа асуудлыг Монгол Улсын хууль, тогтоомжийн дагуу зохицуулна.

**БОРЛУУЛАГЧИЙН ГЭРЭЭНИЙ
НӨХЦӨЛҮҮД**

1. Борлуулагч нь 18 нас хүрсэн бөгөөд хуулийн дагуу гэрээнд орох эрхтэй байна.
2. Юнисити Интернэшнл компаний (цаашид “Юнисити” гэх) энэхүү гэрээг хүлээн зөвшөөрснөөр борлуулагч нь Юниситигийн бие даасан гэрээлэгч болох бөгөөд Юниситигийн Цалинжуулалтын Системийн дагуу Юниситигийн бүтээгдэхүүнүүдийг худалдаалах эрх бүхий албан ёсны борлуулагч болно. Энэхүү гэрээ нь Юниситигийн Дүрэм Журам болон борлуулагчийн гэрээний нөхцөлүүд зөрчигдөөгүй тохиолдолд Юниситигийн мэдээллийн санд орсноор хүчин төгөлдөр болно. Өргөдлийн буруу мэдээлэл болон борлуулагчийн гэрээний нөхцөлүүд нь зөрчигдсөн гэж тооцвол Юнисити энэхүү гэрээг цуцлах эрхтэй.
3. Борлуулагч нь Цалинжуулалтын Систем болон Юниситигийн Дүрэм Журамтай уншиж танилцсан бөгөөд эдгээрийн нөхцөлүүд, гэрээнд оруулсан засвар, хавсралт, нэмэлт өөрчлөлтүүдийг даган мөрдөнө. Энэхүү гэрээ (цаашид “Гэрээ” гэх) нь мөн Цалинжуулалтын Систем болон Юниситигийн Дүрэм Журмыг хамруулсан нэгтгэсэн гэрээ юм. Юниситигийн албан ёсны төлөөлөгч болон борлуулагчийн гарын үсгээр баталгаажсан бичгээр үйлдсэн баримтгүйгээр ямар нэгэн нэмэлт амлалт, баталгаа, болон гэрээ нь хүчингүй байна. Гэрээний нөхцөлүүд болон үүрэг хариуцлагаа зөрчсөн тохиолдолд Юнисити нь Гэрээг дангаар болон давуу эрхтэйгээр дуусгавар болгох эрхтэй. Дүрэм Журам, Цалинжуулалтын Систем болон Гэрээний нөхцөлүүд хоорондоо зөрчилдсөн тохиолдолд одоогийн Дүрэм Журмыг мөрдлөгө болгоно.
4. Борлуулагч болоход бүтээгдэхүүн худалдан авах шаардлагагүй бөгөөд зөвхөн албан ёсны борлуулагчийн зөвшөөрлийн төлбөрийг төлөх үүрэгтэй. Ингэснээр албан ёсны борлуулагчийн бүхий л эрхийг эдэлнэ.
5. Идэвхжүүлэлтийн захиалгын нөхцөлүүд. Идэвхжүүлэлтийн нөхцөлийг зөвшөөрч идэвхжүүлэлтийн системд хамрагдсанаар Юнисити сар бүр заасан төлбөрийн хэлбэрийг ашиглан идэвхжүүлэлтийн захиалгыг сар бүрийн 20-ноос хоцролгүйгээр илгээнэ. Юнисити нь төлбөрийг бүрэн хүлээн автал ямарваа бүтээгдэхүүн илгээхгүй бөгөөд төлбөр баталгаажснаа хойш ойролцоогоор хоёр өдрийн дотор захиалгыг илгээнэ. Шинээр оруулсан идэвхжүүлэлтийн захиалга нь мөн хоёр өдрийн дотор илгээгдэнэ. Түүнээс хойш сар болгон идэвхжүүлэлтийн захиалга нь илгээгдэнэ. Идэвхжүүлэлтийн захиалга нь тусгайлан өдөр заагаагүй бол захиалгыг хүлээн авснаас хойш 3-5 хоногийн дараа илгээгдэнэ. Идэвхжүүлэлтийн захиалга бүр дээр тэвэрийн зардал нэмж тооцогдоно.
 - А. **Идэвхжүүлэлтийн захиалга.** Энэ систем нь Цалинжуулалтын Системд хамрагдахад шаардлагатай тухайн сарын идэвхжүүлэлтийн оноог автоматаар бүрдүүлэх нөхцөлийг бий болгоно.
 - Б. **Өөрчлөлт.** Дүрэм Журамд заасны дагуу идэвхжүүлэлтийн захиалгандаа өөрчлөлт хийх боломжтой.
 - В. **Цуцлалт.** Идэвхжүүлэлтийн захиалгын гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 90 хоногийн дотор гэрээгээ цуцлаж болохгүй. Идэвхжүүлэлтийн захиалгын гэрээг цуцлахдаа шинэ гэрээн дээр “Идэвхжүүлэлтийн захиалга зогсоох” гэж бичин явуулна. Хэрэглэгчдэд үйлчлэх хэлтэс нь цуцлах мэдэгдлийг дараачийн идэвхжүүлэлтийн захиалгын илгээлтийн өдрөөс ажлын 10 өдрийн өмнө хүлээн авсан байх ёстой. Цуцлах мэдүүлгийг илгээлтийн өдрөөс ажлын 10 хоногийн дотор хүлээн авсан тохиолдолд сүүлчийн захиалга илгээгдэхгүй гэсэн баталгаа байхгүй. Идэвхжүүлэлтийн захиалгыг буцаах боломжгүй бөгөөд хэрвээ илгээлт хийхээс ажлын 10 хоногийн өмнө цуцалснаа тодорхой баримттай баталж чадвал буцаах боломжтой.
 - Г. **70%-ийн дүрэм.** Бүтээгдэхүүний захиалга хийхдээ урьд хийсэн захиалгануудынхаа доод тал нь 70 хувийг (70%) худалдсан байх ёстой.
6. Борлуулагчийн Гэрээ нь хүчин төгөлдөр болсноос хойш нэг (1) жилийн турш хүчинтэй бөгөөд жил бүр шинэчлэгдэх шаардлагатай. Юнисити нь Борлуулагчийн Гэрээг шинэчлэх хариуцлага хүлээхгүй. Хэрэв ямар нэгэн шалтгаанаар шинэчлэгдээгүй тохиолдолд Юнисити Гэрээг цуцлах эрхтэй. Энэхүү Гэрээгээр үүссэн албан ёсны гэрээт борлуулалт нь цуцлагдах боломжтой эрх бөгөөд борлуулагчийн үүсгэсэн байр суурь нь Юниситигийн өмч болно.
7. Хэрэв Борлуулагчийн Гэрээг цуцлахыг хүсвэл Юниситид бичгээр мэдэгдэнэ. Цуцлах мэдэгдэл Юниситид хүргэгдэн хүлээн зөвшөөрөгдсөнөөр цуцлалт хүчин төгөлдөр болно.
8. Борлуулагч нь Юниситигийн ажилтан, хамтрагч, агент, хамтран эзэмшигч, болон хууль ёсны төлөөлөгч биш, бие даасан гэрээлэгч юм. Борлуулагч нь өөрт болон өөрийн бизнес хамраах аливаа хууль, дэг журмыг сахин биелүүлэх үүрэгтэй ба хэрэглэсэн болон борлуулсан бүтээгдэхүүнд оногдох бүх төрлийн татвар хураамжийг тухайн бизнесийн харьяалагдах хууль тогтоомжийн дагуу төлнө (Юнисити өөрөөр заагаагүй бол).
9. Юнисити болон түүний харьяа байгууллагууд нь борлуулагчид өөрийн бизнесийн үйл ажиллагаагаа явуулахад мөрдөгдөх хууль тогтоомж, дүрэм журам, шаардлагуудтай танилцахад тусалж болох боловч хуулийн хүрээнд бизнесээ явуулах нь борлуулагчийн бие даасан үүрэг юм. Тиймээс Юнисити болон түүний харьяа байгууллагууд, ажилтан, албан хаагчид нь борлуулагчийн өмнөөс хариуцлага хүлээхгүй. Борлуулагчийн буруутай үйл ажиллагаанаас үүссэн аливаа хохирол, нэхэмжлэлийг борлуулагч өөрөө нөхөн төлөх үүрэгтэй.
10. Энэхүү Борлуулагчийн Гэрээ нь АНУ болон түүний харьяа нутаг дэвсгэрт борлуулагч элсүүлэх эрх олгох бөгөөд Дүрэм Журамд зааснаар Юнисити Амбассадор программын хүрээнд бусад улсуудад борлуулагч элсүүлэх эрх олгоно.
11. Зөвхөн Юниситигээр зөвшөөрөгдсөн албан ёсны борлуулагч нь шинээр борлуулагч элсүүлэх эрхтэй. Юнисити нь энэхүү Гэрээг ямарваа нэгэн тайлбар өгөлгүйгээр хүлээн зөвшөөрөхгүй байж болно. Хэрвээ Гэрээ нь Юниситигаар хүлээн зөвшөөрөгдөөгүй тохиолдолд Юнисити болон түүний харьяа байгууллагууд, ажилтан, албан хаагчид нь борлуулагчийн өмнөөс хариуцлага хүлээхгүй.
12. Борлуулагч нь өөрийн элсүүлсэн борлуулагч болгоныг сургах, дэмжих үүрэгтэй бөгөөд эцсийн хэрэглэгчид бүтээгдэхүүн хүрэх хүртэл бүх шатанд бүхий л чадлаараа хяналт тавьж ажиллана. Мөн шинээр элсүүлэх боломж бүхий борлуулагчдын өмнө мөн адил үүрэг хүлээнэ. Борлуулагч нь өөрийн үүсгэсэн байгууллагатай байнгын харилцаа холбоотой байж хяналт тавин ажиллана.
13. Юниситигээс авах шагнал урамшуулал нь Цалинжуулалтын Системийн дагуу олгогдох бөгөөд зарим тохиолдолд Юниситигийн тусгай урамшууллын программын дагуу олгогдоно.
14. Юниситигийн бүтээгдэхүүнийг хувирган өөрчлөх, дахин боож баглах, шошгийг өөрчилж болохгүй бөгөөд Юниситигийн зааснаас өөр заавар, нэрээр зарж болохгүй. Түүнчлэн, Юниситигээр батлагдаагүй ямар нэгэн цалинжуулалтын систем, төлөвлөгөө, бичлэг, товхимол болон бусад материалыг ашиглагаж болохгүй.
15. Борлуулагч нь энэхүү гэрээгээр үүсэх эрхээ Юниситигийн бичгэн зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулж, шилжүүлж болохгүй. Юнисити борлуулагчийн зөвшөөрөлгүйгээр гэрээг шилжүүлж болно.
16. Юниситигийн бичгэн зөвшөөрөлгүйгээр түүний барааны нэр, барааны тэмдэг болон бусад өмчийг ашиглаж болохгүй.
17. Юниситигийн бүтээгдэхүүний үр дүн болон Цалинжуулалтын Системийн талаар Юниситигээс гаргасан албан ёсны материалаас өөр амлалт өгч болохгүй.
18. Юнисити болон түүний харьяа байгууллагууд нь борлуулагчид болон борлуулагчдын нэрсийн жагсаалтыг өмчлөх эрхтэй. Өөрийн спонсорлоогүй борлуулагчиддаа борлуулагчдын нэрсийн жагсаалт, Юниситигээс гаргаагүй ямар нэгэн бүтээгдэхүүн, программ, үйлчилгээг ашиглан худалдаа хийхийг хориглоно. Цалинжуулалтын Системд товлон заагаагүй бол борлуулагч нь нэгээс илүү борлуулагчийн эрх олж авах ашгийн сонирхолтой байх ёсгүй. Борлуулагчийн нэрсийн жагсаалтыг Юниситигийн хүсэлт болон гэрээ дуусгавар болоход Юниситид буцааж өгнө.
19. Юниситигээс бүтээгдэхүүн худалдан авахдаа эзэлийн карт эсвэл харилцах дансны карт ашиглах тохиолдолд энэхүү гэрээнд зурсан гарын үсэг нь гүйлгээ хийх зөвшөөрлийг олгоно.
20. Гэрээний аль нэг заалт хүчин төгөлдөр бус болох тохиолдол бусад заалтуудын хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй.
21. Энэ Гэрээ нь Юта мужийн хуульд захирагдана. Аливаа маргааныг Юниситигийн харьяалагдах Солт Лэйк болон Юта дүүргийн шүүхээр шийдвэрлүүлнэ. Буруутай тогтоогдсон тал нь нөгөө талынхаа өмгөөлөгчийн болон шүүх хуралтай холбоотой бусад гарсан зардлуудыг төлөх үүрэгтэй.
22. Бүх төрлийн маргааны үед Юнисити болон түүний харьяа байгууллагууд, ажилтан, албан хаагчид нь хариуцлага хүлээхгүй. Маргаан үүсгэсэн шалтгаан бий болсон өдрөөс хойш нэг жилийн дотор аль нэг тал нь гомдол гаргах эрхтэй.
23. Энэхүү Борлуулагчийн Гэрээнд өгсөн бүх мэдээлэл үнэн зөв байна. Аливаа худал, буруу мэдээлэл нь Борлуулагчийн гэрээг хүчингүй болгоно.